МЭДЭЭ · 2025 оны 2-р сарын 11

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТНЫ 2025 ОНЫ НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨН БОЛЖ БАЙНА



Прокурорын байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох, цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Прокурорын байгууллагын удирдах ажилтны 2025 оны нэгдсэн зөвлөгөөн” зохион байгуулагдаж байна.

Энэ удаагийн зөвлөгөөн “Прокурорын цахимжилт-Ил тод байдал” сэдвийн дор зохион байгуулагдаж, прокурорын байгууллагаас 2024 онд хийсэн ажил, хүрсэн үр дүн, цаашид баримтлах бодлого чиглэлээ хэлэлцэх юм.

Нэгдсэн зөвлөгөөнд Улс, аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын дээд шатны прокурорууд оролцож байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1079